



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/614

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Ландкрузер 76 маркын суудлын автомашиныг засварлахад шаардагдах сэлбэгийн үнэ 2555000 /хоёр сая таван зуун тавин таван мянга/ төгрөгийг захиалагчийн хяналтын зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Аззаяа/-д зөвшөөрсүгэй.

2. Автомашины засварын ажлыг чанартай гүйцэтгэж, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд захиалагчид хяналт хийх үйл ажиллагааг хэвийн явуулахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Н.Бямбадорж/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын дарга /Х.Ган-Очир/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД